



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар A/89

Даланзадгад сум

Эрүүл мэндийн салбарын оны шилдгүүдийг  
шалгаруулах журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.1, 51.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, тухайн жилдээ хамт олноо манлайлан, шинэ санал санаачилга дэвшүүлж, хариуцсан ажилдаа онцгой амжилт гарган ажилласан эмч, эмнэлгийн ажилчдыг тодруулах "Эрүүл мэндийн салбарын оны шилдгүүдийг шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тус журмын дагуу оны шилдгүүдэд тодорхойлох материалыг хугацаанд нь хүлээн авч Удирдлагын багаар хэлэлцүүлэхийг Эрүүл мэндийн салбарын шагнал урамшуулал, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ж.Наранжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Б.Мидэрсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА   
Ц.ЖАВЗАНДУЛАМ

Эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны ~~12~~<sup>13</sup>-дугаар сарын ~~01~~<sup>02</sup>-ний өдрийн  
~~A/89~~ дугаар тушаалын хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ОНЫ ШИЛДГҮҮДИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах эмнэлгийн тусlamж үйлчилгээнд шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлэн эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гарган ажиллаж байгаа тэргүүний байгууллага, хамт олон төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа ажилчдыг шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрднө.

### Хоёр. Шагналын төрөл

- 2.1. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг байгууллага, хамт олон"
- 2.2. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг эмч"
- 2.3. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг эмнэлгийн мэргэжилтэн"
- 2.4. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг сувилагч"
- 2.5. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг тусгай мэргэжилтэн"
- 2.6. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг ажилтан"

### Гурав. Шалгаруулах болзол

- 3.1. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг байгууллага, хамт олон"
  - 3.1.1. Эмнэлгийн тусlamж үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх
  - 3.1.2. Тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 90-ээс дээш хувьтай байх
  - 3.1.3. Өр авлагагүй ажилласан байх
  - 3.1.4. Байгууллага хамт олон ёс зүйн алдаа зөрчилгүй, гомдол гаргаагүй ажилласан байх
  - 3.1.5. Ажилчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын биелэлт 90-ээс дээш хувьтай байх
  - 3.1.6. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны үнэлгээ
- 3.2. Эрүүл мэндийн салбарын "Шилдэг эмч"
  - 3.2.1. Стандарт эмнэлзүйн удирдамжийг мөрдөн эмчилгээ үйлчилгээг ээлтэй болгоход чиглэсэн үйлчилгээ эмчилгээ оношилгооны дэвшилтэд технологийг нэвтрүүлэн үр дүнд хүрсэн байх
  - 3.2.2. Үйлчлэх хүрээний хүн амыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байх

- 3.2.3. Иргэдийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх болон байгууллагыг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байх
- 3.2.4. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарын багийн ажлыг сайжруулах эмнэлэүйн удирдамжийг бүрэн хэрэгжүүлэх ижил мэргэжлийн үзлэг шинжилгээг явуулсан байх
- 3.2.5. Мэргэжлийн алдаа болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа гаргаагүй байх
- 3.2.6. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгчдээс санал, гомдол гаргаагүй байх
- 3.2.7. Олон улсын болон аймгаас зохион байгуулсан эрдэм шинжилгээний болон онол практикийн хуралд илтгэл тавьсан бол давуу тал болно
- 3.2.8. Тухайн жилдээ иргэдийн эрүүл мэндэд чиглэсэн онцгой, өвөрмөц, үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах, оролцсон байх
- 3.3. Эрүүл мэндийн салбарын “Шилдэг эмнэлгийн мэргэжилтэн”**
- 3.3.1. Нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн төсөл, хөтөлбөр санаачлан олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үр дүнтэй ажилласан байх
- 3.3.2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээг чанартай хүргэхэд өөрийн хариуцсан ажил үүргийн хүрээнд амжилттай, ахиц дэвшлийг гарган дэмжин ажилласан байх
- 3.3.3. Эрүүл мэнд, эм зүйн салбарт мөрдөгдөж байгаа стандарт дүрэм журмыг мөрдөн ажиллаж, үйл ажиллагаанд шинэ санал санаачилга, технологи нэвтрүүлсэн байх
- 3.3.4. Иргэдийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн байх
- 3.3.5. Мэргэжлийн алдаа болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа гаргаагүй байх
- 3.3.6. Олон улсын болон аймгаас зохион байгуулсан эрдэм шинжилгээний болон онол практикийн хуралд илтгэл тавьсан бол давуу тал болно.
- 3.4. Эрүүл мэндийн салбарын “Шилдэг сувилагч”**
- 3.4.1. Нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх ажилд идэвх санаачилгатай ажиллан олон нийтэд хүргэх эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг тогтмолжуулан ажилласан байх
- 3.4.2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээнд шинэлэг зүйл санаачлан хийж шинэ технологи нэвтрүүлэн үр дүнг тооцож тусlamж үйлчилгээнд чанарын ахиц гарсан байх

- 3.4.3. Иргэд үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх эрүүл мэндийн зөв дадал хэвшил болгох гарын авлага санамж материал шинээр санаачлан хийсэн байх
  - 3.4.4. Сувилахуйн тусlamж үйлчилгээний стандарт удирдамжуудыг хэрэгжүүлж, чанарыг сайжруулсан байх
  - 3.4.5. Асаргаа, сувилгааны тусlamж үйлчилгээнд ахиц, дэвшил гаргаж үр дүнг тооцсон байх
  - 3.4.6. Олон улсын болон аймгаас зохион байгуулсан эрдэм шинжилгээний болон онол практикийн хуралд илтгэл тавьсан бол давуу тал болно
  - 3.4.7. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн болон мэргэжлийн алдаа зөрчил, үйлчлүүлэгчдээс санал, гомдол гаргаагүй байх
- 3.5. Эрүүл мэндийн салбарын “Шилдэг тусгай мэргэжилтэн”**
- 3.5.1. Нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх ажилд идэвх санаачилгатай ажиллан олон нийтэд хүргэх эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг тогтмолжуулан ажилласан байх
  - 3.5.2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээнд шинэлэг зүйл санаачлан хийж шинэ технологи нэвтрүүлэн үр дүнг тооцож тусlamж үйлчилгээнд чанарын ахиц гарсан байх
  - 3.5.3. Иргэд үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх эрүүл мэндийн зөв дадал хэвшил болгох гарын авлага санамж материал шинээр санаачлан хийсэн байх
  - 3.5.4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн болон мэргэжлийн алдаа зөрчил, өргөдөл гомдол гаргаагүй байх
  - 3.5.6. Тусгай мэргэжлийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр ажил санаачлан зохион байгуулсан эсэх
- 3.6. Эрүүл мэндийн салбарын “Шилдэг ажилтан”**
- 3.6.1. Эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг ханган ажилласан байх
  - 3.6.2. Үйлчлүүлэгчдэд ая тухтай ээлтэй орчин бүрдүүлэхэд оновчтой шинэ санал санаачилга гарган ажилласан байх
  - 3.6.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн нөхцөлийг хангаж эмнэлгээс шалтгаалах халдвартын дүрэм зааврыг мөрдөн ажилласан байх
  - 3.6.4. Эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр алдаа зөрчил гаргаагүй байх